



Хавсралт ба – Нийгэм ба байгаль орчинд үзүүлэх нөлөөллийн хурдавчилсан дүн шинжилгээ

УУР АМЬСГАЛЫН НОГООН САНГИЙН
САНХҮҮЖҮҮЛЭЛТИЙН САНАЛ



Хавсралт ба: Нийгэм ба байгаль орчинд үзүүлэх нөлөөллийн хурдавчилсан дүн шинжилгээний маягт

Нийгэм ба байгаль орчинд үзүүлэх нөлөөллийн хурдавчилсан дүн шинжилгээний (SESP) тайланг бүрдүүлсэн уг маягтыг бүрэн дүүрэн бөглөөд Төслийн баримт бичигтэй хамт хавсаргах ёстой. Эдгээр 6 асуултанд хэрхэн хариулах талаарх [Нийгэм ба байгаль орчинд үзүүлэх нөлөөллийн хурдавчилсан дүн шинжилгээний журам](#) болон [Арга хэрэгслийг](#) үзнэ үү.

Төслийн мэдээлэл

Төслийн мэдээлэл	
1. Төслийн нэр	Монгол улсын хөдөө орон нутгийн ард иргэдийн дасан зохицох чадварыг сайжруулах нь
2. Төслийн дугаар	5873
3. Байршил (Дэлхийн/Бүс нутгийн/Улсын)	Монгол улс

А бүлэг. Нийгэм ба байгаль орчны тогтвортой байдлыг бэхжүүлэх нийтлэг зарчмуудыг уялдуулах нь

АСУУЛТ 1: Нийгэм болон байгаль орчны тогтвортой байдлыг бэхжүүлэхийн тулд уг төсөл нь хэрхэн нийтлэг зарчмуудыг уялдуулах вэ?

Доорх хэсэгт уг төсөл нь хэрхэн хүний эрхэд тулгуурласан арга барилыг үндсэн чиглэл болгон хэрэгжүүлэх талаар товч тайлбарлана уу

Төсөл нь малчин өрх бүлүүдийг байгалийн нөөцийг ашиглагч бүлгүүдийн зохион байгуулалтанд оруулж мөн Засгийн газрын эрх бүхий байгууллагууд болон малчин өрх бүлүүдийн хооронд байгуулсан Байгалийн нөөц ашиглалтын гэрээнд тулгуурласан уламжлалт газрын эрх болон усны нөөц эх үүсвэрийг дэмжиж ажиллахын тулд орон нутгийн засаг захиргаатай хамтран ажиллах замаар малчин өрх бүлүүдийн нийгмийн болон байгалийн өв хөрөнгийн аль алийг нь сайжруулж ажиллах болно.

Төсөл нь оролцоог дэмжихийн тулд нутгийн ард иргэдийг дайчилж мөн нутгийн ард иргэд болон албан хаагчдын чадавхийг бэхжүүлж, хэрэгжилтийн үе шатны явцад төслийн хөндлөнгийн оролцоог зохих түвшинд боловсронгуй болгохын тулд хөрөнгө оруулах болно. Засгийн газар, нутгийн ард иргэд болон бусад түнш байгууллагуудын гүйцэтгэх үүрэг, хариуцлагыг хамарсан хамтын менежментийн тогтолцоогоор дамжуулан нутгийн ард иргэдтэй нягт хамтран ажиллах болно.

Доорх хэсэгт уг төсөл нь хүйсийн тэгш байдал болон эмэгтэйчүүдийн эрх мэдлийг хэрхэн сайжруулж болох талаар товч тайлбарлана уу

Уур амьсгалын өөрчлөлт болон түүний нөлөөлөл нь хүйсийн тэгш байдлын хувьд төвийг сахисан байж чадахгүй байна. Эрэгтэйчүүд болон эмэгтэйчүүдийн хувьд, уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөлөл, түүнчлэн даван туулах нөөц боломж, чадавхи, механизмыг давамгайлах болоод буй нийгэм, соёлын хэм хэмжээ, гендэрийн хэвшмэл ойлголт, ядуурлын түвшин, үйлдвэрлэлийн хөрөнгө, нөөц хөрөнгөд тавьж буй хяналт гэх мэтийн олон хүчин зүйлс маш ихээр албадан барьж байдаг байна. Уур амьсгалын өөрчлөлт нь хүйсийн байдалд суурилсан өнөөгийн хэв загварыг улам илэрхий болгох хандлагатай байна.

Хүйсийн тэгш байдлын үнэлгээ болон Үйл ажиллагааны төлөвлөгөөг (YAT) бэлдэж боловсруулсан байгаа. Энэхүү YAT нь төслийн үйл ажиллагааны хэсэг тус бүрийн хүрээнд хийгдэх хүйсийн тэгш байдалд чиглэсэн арга хэмжээ авахыг санал болгосон, туршилтын хүрээнд нэвтрүүлэх арга хэмжээг гаргаж өгсөн. Хүйсийн тэгш байдал болон эмэгтэйчүүдийн эрх мэдлийг бэхжүүлж, сайжруулах боломжтой зарим чиглэлийн ажлыг дурдвал: эрэлт хэрэгцээ, одоогоор байгаа бодлогын баримт бичигт (ж нь, усны нөөц болон газрын менежмент) хүйсийн тэгш байдлыг гол чиглэл болгон, эрэлт хэрэгцээ болон тулгамдаж буй сорилтод хангалттай хэмжээний хариу арга хэмжээ авах нөхцлийг бүрдүүлэх зөвлөгөөнд оролцох, хүйсээр ангилан ялгасан тоон мэдээлэл өгөгдлийг цуглуулах, үндэсний болон аймаг/сум орон нутгийн түвшинд ажиллаж буй бодлого боловсруулагч нарыг хүйсийн тэгш байдлын эрэлт хэрэгцээний талаар мэдрэмжтэй болгох, тухайн эрэлт хэрэгцээнд нийцсэн чадавхийг буй болгох, техникийн сургалтанд эмэгтэйчүүдийг хамруулах, зах зээлд нэвтрэх нөхцөл, үнийн бодлого ба уур амьсгалын талаарх мэдээлэл, эмэгтэйчүүдийн оролцоог хангаж, дэмжих санхүүгийн механизмыг буй болгох зэрэг болно.

Доорх хэсэгт төсөл хэрхэн байгаль орчны тогтвортой байдлыг үндсэн чиглэл болгон хэрэгжүүлэх талаар товч тайлбарлана уу

Байгаль орчны тогтвортой байдлын чухал бүрэлдэхүүн хэсэг бол боломж нөхцлийг бүрдүүлсэн орчинтой байх явдал юм. Энэ зорилтыг биелүүлэхийн тулд, төслийн хүрээнд бүх түвшинд чадавхийг бэхжүүлэхэд чиглэсэн, институтын түвшинд чадавхийг бэхжүүлэх дэд бүрэлдэхүүн хэсгийг хамруулах болно: үндэсний хэмжээнд, төр болон орон нутгийн засаг захиргааны харьяалал болон орон нутгийн иргэд орно. Төслийн бүх бүрэлдэхүүн хэсгийн хүрээнд сайн бэхжүүлсэн институтууд, үйл явц, тогтолцоонууд, уур амьсгалд хариу үйлдэл үзүүлэхүйц төлөвлөлт болон хэрэгжилтэд чиглэсэн хүний нөөц, институт, эрх зүйн тогтолцоог сайжруулсаны үр дүнд, хүн хүчний болон дэд бүтцийн чадавхийг бэхжүүлж, тогтвортой байдлыг сайжруулна гэсэн хүсэн хүлээлт байгаа.

Төслийн зүгээс усны аюулгүй байдлыг дэмжихийн тулд бүтцийн болон экосистемд тулгуурласан арга хэмжээг хоёуланг нь хөхиүлэн дэмжиж ажиллах болно. Үүнд [хөрсний] ус чийг барих чадвар болон бэлчээрийн гарцыг нэмэгдүүлэхийн тулд голын эрэг хавийн талбай болон доройтсон газрыг дагуулан нутгийн уугуул ургамал ногоог дахин тариалах болно. Гүний усыг олборлож байгаа газарт усны хэрэглээг хянаж, бүтээмжийг сайжруулахын сацуу олборлолт болон технологийн ашиглалтыг сайжруулахын тулд төслийн зүгээс хамтрагч талуудтай хамтран ажиллах болно. Гүнзгий жалга суусан газарт ургамал амьтны амьдрах тааламжтай орчинг (habitat) нөхөн сэргээж, унаган байдлыг нь хэвийн хэмжээнд хадгалах үүднээс хөрсний элэгдлийг хянах бага хэмжээний барилгын ажилд хөрөнгө оруулах болно. Үүнд усны урсгалын хүрдцыг бууруулах, хөрсний ус, чийгийг барьж, байгалийн урсац болон өвс ургамал, ургамалшлыг сэргээхэд чиглэсэн олон улсын амжилттай хэрэгжүүлсэн арга туршлагаудад тулгуурлан ус халиагуур боомтыг ашиглан ус цуглуулах зэрэг ажлыг хамарч болох юм.

Гарч болзошгүй сөрөг нөлөөллийн хувьд ерөнхийдөө үүнийг төсөл хэрэгжүүлж буй газар нутгийнх нь хүрээнд тогтоон хязгаарлаж мөн [сөрөг] нөлөөллийг бууруулах арга хэмжээг хэрэгжүүлэх замаар зохицуулах боломжтой гэж үзсэн болно, тийм учраас төслийн хүрээний байгаль орчны эрсдлийн хувьд дүнд зэрэг (Б ангилал) байна гэж үнэлсэн байгаа ба хязгаарлагдмал цар хүрээнд боломжийн түвшинд эргэлзэхээргүй байж болно гэж үзсэн ба сөрөг нөлөөллийг бууруулах зохих арга хэмжээ авах замаар үүнийг шийдэх боломжтой гэж үзсэн болно. Төслийн Байгаль орчин, нийгмийн хүрээний удирлага, зохион байгуулалтын бүтэц, хамрах хүрээний (ESMF) хувьд бий болж

болохуйц эрсдлийг олж тодорхойлсон бөгөөд, төслийн зүгээс үзүүлэх нөлөөллийг багасгахын тулд түүнээс зайлсхийх мөн сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээг санал болгосон болно.

Б бүлэг. Нийгэм, эдийн засгийн эрсдлийг олж тодорхойлон, удирдан зохион байгуулах нь

<p>АСУУЛТ 2: Нийгэм ба байгаль орчны хүрээнд үүсч болох ямар эрсдлүүд байна? <i>Тэмдэглэл: Хавсралт 1-д дурдсан Эрсдлийн хурдавчилсан үнэлгээний хүрээнд Шалгах зүйлсийн жагсаалтанд (“Тийм” гэж өгсөн аливаа хариултанд тулгуурлан) олж тодорхойлсон байж болох нийгэм ба байгаль орчны эрсдлүүдийг товч тайлбарлана уу.</i></p>	<p>АСУУЛТ 3: Байж болох нийгэм ба эдийн засгийн эрсдлүүдийн ач холбогдлын түвшин нь ямар вэ? <i>Тэмдэглэл: Асуулт 6-д хариулахаасаа өмнө доорх Асуулт 4 ба 5-д хариулна уу.</i></p>			<p>АСУУЛТ 6: Байж болох эрсдлийг (Дунд болон Өндөр түвшний ач холбогдолтой эрсдлүүдийн хувьд) шийдэхийн тулд Нийгэм ба байгаль орчны ямар үнэлгээ болон удирдлага, зохион байгуулалтын арга хэмжээг хэрэгжүүлээд байгаа болон/эсвэл хэрэгжүүлэх шаардлагатай вэ?</p>
<p>Эрсдлийн тайлбар</p>	<p>Нөлөөлөл ба магадлал (1-5)</p>	<p>Ач холбогдол (бага, дунд, өндөр)</p>	<p>Санал</p>	<p>Төслийн төлөвлөгөөнд тусгасан үнэлгээ болон менежментийн арга хэмжээг тайлбарлана уу. Хэрвээ Байгаль орчин ба нийгэмд үзүүлэх нөлөөллийн үнэлгээ (ESIA) болон Байгаль орчин ба нийгмийн стратегийн үнэлгээг (SESA) хийх шаардлагатай бол уг үнэлгээ нь байж болохуйц бүх нөлөөлөл болон эрсдлийг харгалзан авч үзэх ёстой гэдгийг анхаарна уу.</p>
<p>Эрсдэл 1: Төрийн албан хаагчид болон нутгийн ард иргэдийн гишүүдийн хувьд хязгаарлагдмал нөөц чадавхитай байдаг.</p>	<p>I = 2 P = 3</p>	<p>Дунд зэрэг</p>		<p>Хэд хэдэн чухал гэрээнүүдийг зохистой түвшинд боловсруулж, хэрэгжүүлэх нөхцлийг хангахын тулд төслийн зүгээс орон нутгийн түвшинд нутгийн ард иргэд, малчид, төрийн албан хаагчдад зориулан идэвхижүүлэн дайчлах, техникийн чадавхийг бэхжүүлэх ажилд хөрөнгө оруулах болно.</p> <p>Орон нутгийн болон үндэсний түвшний агентлагуудын техникийн сургалт, чадавхи бэхжүүлэх болон хяналт шалгалтын ажлууд нь [төслийг] боловсруулж, хэрэгжүүлэх тогтвортой чадавхийг бий болгоно.</p> <p>Хэрэгжилтийн явцад, салбар хоорондын уялдаа зохицуулалттай холбоотой сорилтуудыг даван туулахын тулд тууштай хэрэгжилт болон төслийн удирдлага, зохион байгуулалтын бүтэц, хамрах хүрээг (яамдууд, үндэсний агентлагууд, хөдөө орон нутгийн ард иргэд, малчид, бусад хамтрагч талууд) байгуулсан. Төслийн зүгээс БОЯ, ХХААХҮЯ болон бусад агентлагуудыг (UNDP, IFAD, SDC, and WB)</p>

				хамруулсан, үндэсний болон аймаг, сүм орон нутгийн түвшний томоохон олон агентлагуудтай үргэлжлүүлэн хамтран ажиллаж, чадавхийг нь бэхжүүлэх ажлыг хийх болно.
Эрсдэл 2: Усны хэрэглээ, бэлчээр, дэд бүтэц, ойн орчмын ашиг хүртэгчдийн хоорондох зөрчилдөөний эрсдэл.	I = 2 P = 2	Бага	Бэлчээрийг ашиглахтай холбоотой орон нутгийн зөрчил Монгол Улсад ховор тохиолддог зүйл юм.	Өмнөх сургамжаас харахад мөргөлдөөнийг арилгах үндсэн арга хэрэгслийн нэг нь ашиг хүртэгч талуудын хооронд байгуулсан албан ёсны гэрээ, жишээ нь бэлчээр ашиглагч (малчдын) бүлгүүдийн дунд байгуулсан бэлчээрийн гэрээ байна. Уг гэрээнд бэлчээрийг ээлжлэн хуваарийн дагуу ашиглах болон (бэлчээрийн даацаас хэтрүүлэн маллах) бэлчээр нутаг тус бүрт ногдох малын тоо толгойн дээд хэмжээг тогтоох зэрэг зарим нийтлэг дүрэм журмыг агуулсан байдаг. Бусад чухал салбаруудад (ой, ус, дэд бүтэц гэх мэт) үүнтэй төстэй арга барилыг ашигладаг. Гэрээ нь зөрчилдөөнийг арилгах төслийн төлөвлөлтийн үйл ажиллагааны чухал, салшгүй хэсэг юм.
Эрсдэл 3: Төслийн хүрээнд амьжиргаанд зарим нөлөө үзүүлэхүйц газар ба нөөцийн ашиглалтад өөрчлөлт оруулах ажлыг хамруулсан байгаа.	I = 2 P = 2	Бага	Одоогийн байдлаар тогтвортой бус арга ажиллагааны улмаас бэлчээрийн бүс нутагт сөргөөр нөлөөлж байна.	Улирлын дагуу сэлгээн бэлчээрлүүлж, өнжөөж амраах хуваарийг баримтлан хэрэгжүүлдэг тогтвортой менежмент болон бэлчээрийн төлөв байдлыг хэвийн хэмжээнд барьж, малын тоо толгойг тохируулж, бууруулах төлөвлөгөө бүхий, бэлчээр ашиглагчдын бүлгүүд болон сумын засаг захиргааны хооронд тохиролцсон урт хугацааны Бэлчээр ашиглалтын гэрээ байна.
Risk 4: Уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөллийн шок нь төсөлд богино хугацааны хохирол учруулахаас гадна төслийн урт хугацааны тогтвортой байдалд нөлөөлж болзошгүй юм.	I = 3 P = 3	Дунд зэрэг	Уур амьсгалын ноцтой цочролыг ард иргэд хэдүйнээ мэдэрч байна. Төсөл нь дасан зохицох чадвар болон даван туулах уян хатан чанарыг дээшлүүлэх замаар эдгээр цочролын нөлөөллийг бууруулахад чиглэгддэг.	Малчдын бүлгүүдэд зориулан, цаг уурын эрс тэс үзэгдлийн (зуд, ган, үерийн болон бусад үйл явдлууд) сөрөг нөлөөтэй тэмцэх уламжлалт болон орчин үеийн технологийг хослуулан сургалт явуулах болно. Барилга байгууламж (хашаа, уст цэг, тэжээлийн агуулах), тэсвэртэй мал, амьтдын үржлийг сонгох, бэлчээрийг сайжруулах, тэжээл, ус хадгалж агуулах ажилд онцгой анхаарал хандуулах болно. Малчдын бүлгүүдийг мэдээллээр хангах, харилцаа холбоогоор хангаж, уялдуулан зохицуулах ажил, яаралтай тусламжийн нэгжүүдийг зохион байгуулах ажлыг харгалзан авч үзнэ. Экосистемийг сайжруулах нь хүрээлэн буй орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг багасгах боломжтой юм. Үүнээс гадна малчдын орлогыг нэмэгдүүлэх нь уур амьсгалын өөрчлөлтөд өртөмтгий эмзэг байдлыг бууруулж болох юм. Технологи болон зохион байгуулалт, нутгийн ард иргэдийг хөгжүүлэх ажилтай зэрэгцээд, малчид илүү сайн бэлтгэлтэйгээр цаг уурын өөрчлөлтийн ирээдүйн тодорхойгүй байдлыг даван туулах чадвартай байх ёстой.

<p>Эрсдэл 5: Төслийн хүрээнд гадаргын болон гүний усыг олборлох, ус татамжийн эсвэл тогтоон барих байгууламж зэргийг хамруулсан.</p>	<p>I = 3 P = 2</p>	<p>Дунд зэрэг</p>	<p>Одоогоор байгаа цооногууд нь нутгийн ард иргэд болон мал сүргийн төвлөрөл бий болоход хүргэж байна.</p>	<p>Малчдын бүлгүүд Бэлчээр ашиглагчдын бүлгүүдийг байгуулж, Бэлчээр ашиглалтын гэрээ байгуулан (БАГ) ажиллаж эхлэнэ. БАГ-нүүд нь байгалийн нөөцийн тогтвортой ашиглалтын түвшинг тогтоож, илүү сайжруулсан хэлбэрийн байгалийн нөөцийн ашиглалт болон удирдан зохион байгуулалтыг урамшуулахад чиглэсэн болно.</p>
<p>Эрсдэл 6: Төслийг бүтээн босгож, хэрэгжүүлэх хугацаанд, эсвэл хэрэгжүүлэхээ болих үед биет, химийн, биологийн, радиологийн аюулаас үүдэлтэй ажил мэргэжлийн эрүүл мэнд, аюулгүй байдалтай холбоотой байж болох эрсдэл болон эмзэг байдлыг бий болгодог.</p>	<p>I = 2 P = 2</p>	<p>Бага</p>	<p>Төсөлд барилга бүтээн байгуулалтын зарим бүрэлдэхүүн орно. Барилгын ажил нь зарим эрсдэлтэй байдаг боловч зохицуулж болно.</p>	<p>Ажил мэргэжлийн эрүүл мэнд, аюулгүй байдлын тогтсон хэм хэмжээ бүхий урьдчилан сэргийлэх арга хэмжээ болон арга туршлага нь эрсдлийг хүлээн зөвшөөрөхүйц түвшинд хүргэж бууруулахад хангалттай байх болно. Төслийн хэрэгжилтийн хүрээнд барилгын аюулгүй байдлыг хамруулсан байдаг Байгаль орчин, нийгмийн хүрээний удирлага, зохион байгуулалтын бүтэц, хамрах хүрээг (ESMF) ашиглах болно.</p>
<p>Эрсдэл 7: Төслийн хүрээнд зарим (аюултай бус) хог, хаягдал үүсэх болно.</p>	<p>I = 2 P = 3</p>	<p>Дунд зэрэг</p>	<p>Буй болох хог хаягдал нь аюултай бус байх бөгөөд өөр зорилгоор ашиглаж болох түүхий эд, материалын эх үүсвэр болгож ашиглах боломжтой. Хог хаягдлын үйлдвэрлэл нь барилгын ажлын дагавар бүтээгдэхүүн байх бөгөөд эдгээр нь хэмжээний хувьд харьцангуй бага байх болно. Хог хаягдлын төрөлд сав баглаа боодол, ашигласан сав, илүүдэл түүхий эд (чулуу, мод, шороо) орно.</p>	<p>Байгаль орчин, нийгмийн хүрээний удирлага, зохион байгуулалтын бүтэц, хамрах хүрээнд (ESMF) агуулсан байдаг хог, хаягдлын зохион байгуулалтын зарчим болох [хог хаягдлаас] зайлсхийж, багасгаж, дахин боловсруулдаг - хог хаягдлын шаталсан зарчмыг нэвтрүүлнэ.</p>
<p>Эрсдэл 8: Зорилтот аймгуудад үндэстний олон янз оршдог бөгөөд үндэстний цөөнх нь эдгээр бүс нутгуудын хүн амын ихэнх хэсгийг бүрдүүлж байдаг.</p>	<p>I = 2 P = 2</p>	<p>Бага</p>	<p>Төлөвлөсөн бүс нутаг бүрт Бэлчээр ашиглалтын гэрээ (БАГ) болон Бэлчээр ашиглагчдын бүлгүүд (PUGs) нь нийгмийн олон янзын бүлгүүдийн төлөөлөөс бүрдсэн байх болно.</p>	<p>Хамтрагч талуудын оролцоог хангах нь оролцоог хангасан бөгөөд соёлын хувьд мэдрэмжтэй байна. БАГ болон БАГ-нүүд нь төлөөллийг хангасан байна. Нутгийн ард иргэд нь газар ашиглалтын төлөвлөгөө болон хөндлөнгийн нөлөөллийн үйл ажиллагааг баталгаажуулах юм.</p>
<p>АСУУЛТ 4: Төслийн эрсдлийн нийт ангилал гэж юу вэ?</p>				

	Аль нэгийг нь сонгох (Нийгэм ба байгаль орчинд үзүүлэх нөлөөллийн хурдавчилсан дүн шинжилгээг (SESP) зааварчилгаа болгож үзнэ үү)	Санал
	<i>Бага эрсдэлтэй</i> <input type="checkbox"/>	
	<i>Дунд зэргийн эрсдэлтэй</i> <input checked="" type="checkbox"/>	
	<i>Өндөр эрсдэлтэй</i> <input type="checkbox"/>	
	АСУУЛТ 5: Олж тодорхойлсон эрсдэл болон эрсдлийн ангилалд тулгуурлан, Нийгэм ба байгаль орчинд үзүүлэх үр нөлөөллийн хурдавчилсан дүн шинжилгээний аль шаардлага нь ач холбогдолтой вэ?	
	Хэрэглэгдэж буй бүх зүйлсийг сонгоно уу	Санал
	Зарчим 1: Хүний эрх	<input checked="" type="checkbox"/>
	Зарчим 2: Хүйсийн тэгш байдал ба Эмэгтэйчүүдийн эрхийг бэхжүүлэх	<input checked="" type="checkbox"/>
	Зарчим 3: Байгаль орчны тогтвортой байдал	<input checked="" type="checkbox"/>
	1. Биологийн олон янз байдлыг хадгалан хамгаалах ба Байгалийн нөөцийн менежмент	<input checked="" type="checkbox"/>
	2. Цаг уурын өөрчлөлтийн сөрөг нөлөөг бууруулах ба дасан зохицох	<input checked="" type="checkbox"/>
	3. Нутгийн ард иргэдийн эрүүл мэнд, аюулгүй байдал, ажиллах нөхцөл	<input checked="" type="checkbox"/>
	4. Соёлын өв уламжлал	<input type="checkbox"/>
	5. Шилжүүлэн нүүлгэх болон дахин нутагшуулах	<input type="checkbox"/>
	6. Нутгийн уугуул ард иргэд	<input checked="" type="checkbox"/>
	7. Бохирдлоос урьдчилан сэргийлэх ба нөөц баялгийн үр ашигтай ашиглалт	<input checked="" type="checkbox"/>

Эцэслэн зөвшөөрсөн, гарын үсэг

Гарын үсэг	Огноо	Тайлбар
Чанарын баталгаажуулалтыг үнэлсэн		Ихэвчлэн НҮБ-ын Хөтөлбөрийн ажилтан буюу тухайн төсөл хариуцсан НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөрийн ажилтан
Чанарын баталгаажуулалтыг зөвшөөрсөн		НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөрийн ахлах менежер, ихэвчлэн НҮБХХ-ийн Улс хариуцсан дэд захирал (DCP), Улс хариуцсан захирал (CD), Дэд суурин төлөөлөгч (DRR), эсвэл Суурин төлөөлөгч (RR). Эцэслэн гарын үсэг зурснаар Төслийн үнэлгээний хороонд өргөн барихаас өмнө, Нийгэм ба

		байгаль орчинд үзүүлэх нөлөөллийн хурдавчилсан дүн шинжилгээг (SESP) “зөвшөөрсөн” гэдгээ нотолж байна.
Төслийн үнэлгээний хорооны Дарга (РАС)		НҮБХХ-ийн талын Төслийн үнэлгээний хорооны дарга. Зарим тохиолдолд Төслийн үнэлгээний хорооны дарга нь мөн Чанарын баталгаажуулалтыг зөвшөөрөгч байж болдог. Эцэслэн гарын үсэг зурснаар Нийгэм ба байгаль орчинд үзүүлэх нөлөөллийн хурдавчилсан дүн шинжилгээ нь (SESP) төслийн үнэлгээний нэг хэсэг байсан гэж үзэж, Төслийн үнэлгээний хорооны зөвлөмжид авч үзнэ.



Annex 6a – Social and Environmental Screening GREEN CLIMATE FUND FUNDING PROPOSAL



(SESP) Хавсралт 1. Нийгэм ба байгаль орчинд үзүүлэх нөлөөллийн хурдавчилсан дүн
шинжилгээний хүрээнд Шалгах зүйлсийн жагсаалт

Шалгах зүйлс Нийгэм ба байгаль орчинд үзүүлж болох нөлөөллийн эрсдлүүд		
Зарчим 1: Хүний эрх		Хариулт (Тийм/ Үгүй)
1.	Уг төсөл нь нөлөөнд өртөж буй хүн ам, ялангуяа нийгмээс гадуурхагдсан бүлгийнхэн (иргэний, улс төр, эдийн засаг, нийгмийн эсвэл соёлын) хүний эрхээ эдлэхэд нь сөрөг нөлөөлөл үзүүлэхэд хүргэх үү?	No
2.	Нөлөөнд өртөж буй хүн ам, ялангуяа ядуурлын түвшинд байгаа ард иргэд эсвэл гадуурхагдсан эсвэл хасагдсан хувь хүн эсвэл бүлэгт төслийн зүгээс алагчилж эсвэл гадуурхсан сөрөг нөлөөлөл үзүүлэх магадлалтай юу? ¹	No
3.	Төсөл нь ялангуяа гадуурхагдсан хүмүүс эсвэл бүлэгт хүрэх нөөц баялгийн бэлэн байдал, чанар, хүртээмжийг хязгаарлаж байж болох үү?	No
4.	Төсөл нь ялангуяа гадуурхагдсан бүлэг зэрэг нөлөөнд өртөж болзошгүй аливаа хамтрагч талуудыг, тэдэнд нөлөөлж болохуйц шийдвэр гаргах үйл явцад бүрэн хэмжээнд оролцохоос нь хасаж байж болох үү?	No
5.	Эрх баригчид төсөлд тусгасан өөрсдийн эрх үүргээ биелүүлэх чадавхгүй байх эрсдэл бий юу?	Yes
6.	Эрх эзэмшигчид өөрсдийнхөө эрхийг шаардах чадваргүй болох эрсдэл бий юу?	No
7.	Хамтрагч талуудыг оролцуулах үйл явцад орон нутгийн ард иргэд эсвэл хувь хүмүүс боломж олдсон үед төсөлтэй холбогдуулан хүний эрхтэй холбоотой асуудлыг дэвшүүлж байсан үү?	No
8.	Төслийн нөлөөнд өртөх нутгийн ард иргэд болон хувь хүмүүсийн дунд зөрчилдөөнийг улам хурцатгах болон/эсвэл хүчирхийллийн эрсдлийг уг төсөл нэмэгдүүлэх эрсдэл байна үү?	Yes
Зарчим 2: Хүйсийн тэгш байдал болон Эмэгтэйчүүдийн эрх мэдлийг бэхжүүлэх		
1.	Санал болгож буй төсөл нь хүйсийн тэгш байдал болон/эсвэл эмэгтэйчүүд болон охидуудын нөхцөл байдалд сөрөг нөлөөлөл үзүүлэх магадлалтай байна үү?	No
2.	Төсөл нь хүйсийн байдал дээр тулгуурлан, ялангуяа төлөвлөлт, хэрэгжүүлэлтийн явцад оролцох эсвэл боломж ба үр ашгийн хүртээмж зэрэг тал дээр эмэгтэйчүүдийн эсрэг ялгаварлан гадуурхал үүсгэх магадлалтай юу?	No
3.	Төслийн талаар эмэгтэйчүүдийн бүлэг/тэргүүлэгчид хамтрагч талуудтай уулзах үеэр төслийн талаар хүйсийн тэгш байдалтай холбоотой асуудал дэвшүүлж байсан үү, мөн тэднийг төслийн нийт санал боловсруулах болон эрсдлийн үнэлгээ хийхэд оролцуулсан байсан үү?	No
4.	Уг төсөл нь байгаль орчны нөөц баялгаас гаралтай бараа болон үйлчилгээний хүртээмжийн хувьд эмэгтэйчүүд болон эрэгтэйчүүд өөр өөр гүйцэтгэх үүрэг болон байр суурьтай байдгийг харгалзан авч үзвэл, эмэгтэйчүүдийн байгалийн нөөц баялгийг ашиглах, боловсруулах, хамгаалах нөөц боломжийг нь хязгаарлаж байх магадлалтай юу? <i>Жишээлбэл, уг төслийн үйл ажиллагаа нь эдгээр байгалийн нөөцөд тулгуурлан амьжиргаагаа болон сайн сайхан аж байдлаа залгуулж байдаг нутгийн ард иргэдийн хувьд тэдгээр байгалийн нөөцийг нь доройтуулж эсвэл хомсдолд хүргэх магадлалтай юу?</i>	No

¹ Ялгаварлан гадуурхахыг хориглосон үндэслэлд арьс өнгө, үндэс угсаа, хүйс, нас, хэл, хөгжлийн бэрхшээл, бэлгийн чиг баримжаа, шашин шүтлэг, улс төрийн болон бусад үзэл бодол, үндэсний болон нийгэм, газарзүйн гарал үүсэл, өмч хөрөнгө, уугуул иргэн эсвэл нийгмийн цөөнхийн гишүүн байх зэргийг хамруулсан төрөлт эсвэл бусад статусыг хамруулан ойлгоно. “Эмэгтэйчүүд болон эрэгтэйчүүд” эсвэл үүнтэй төстэй нэршлийн хувьд эмэгтэйчүүд ба эрэгтэйчүүд, охид ба хөвгүүд, мөн трансжендэр хүмүүс, транссексуалууд гэх мэт тэдний хүйсийн хувьд өвөрмөц онцлог шинж байдлаасаа болоод ялгаварлан гадуурхагдсан хүмүүс гэж ойлгоно.

<p>Зарчим 3: Байгаль орчны тогтвортой байдал: Байгаль орчны эрсдлийн талаарх хурдавчилсан дүн шинжилгээний асуултуудыг доорх стандарт хэм хэмжээтэй холбоотой тодорхой асуултуудад багтаасан болно.</p>	
<p>Стандарт 1: Биологийн олон янз байдлыг хадгалан хамгаалах болон Байгалийн нөөцийн тогтвортой менежмент</p>	
<p>1.1 Төсөл нь ургамал, амьтны ургах, амьдрах таатай орчинд (ж нь, өөрчлөн хувиргасан, байгалийн, онц ач холбогдолтой амьдрах орчин) болон/эсвэл экосистем болон экосистемийн үйлчилгээнд сөрөг нөлөөлөл үзүүлэх магадлалтай юу? <i>Жишээлбэл, амьдрах таатай орчныг нь алдагдуулах, хувирган өөрчлөх эсвэл доройтуулах, хэсэгчилэн хуваах, гидрологийн өөрчлөлтөнд оруулах</i></p>	No
<p>1.2 Төслийн зүгээс санал болгож буй аливаа нэг үйл ажиллагаа нь эрх бүхий байгууллагууд мөн/эсвэл нутгийн уугуул ард иргэд эсвэл орон нутгийн ард иргэдийн хувьд онцгой ач холбогдолтой амьдрах орчин мөн/эсвэл байгаль орчны хувьд эмзэг мэдрэг бүс нутаг, үүнд хуулиар хамгаалагдсан бүс нутгууд (ж нь, байгалийн нөөц газар, үндэсний парк), хамгаалуулахаар санал болгосон газар, эсвэл тийнхүү хүлээн зөвшөөрсөн газар нутгийн бүс дотор эсвэл ойролцоо байрлахаар байна уу?</p>	No
<p>1.3 Төсөл нь амьдрах таатай орчин, экосистем ба / эсвэл амьжиргаанд сөргөөр нөлөөлж болзошгүй газар, нөөцийн ашиглалттай холбоотой өөрчлөх үйл ажиллагааг агуулж байгаа юу? (Тэмдэглэл: Хэрвээ газрын хүртээмжийг хязгаарлаж мөн/эсвэл хязгаарлалт тогтоохоор байгаа бол 5-р стандарт хэм хэмжээг үзнэ үү)</p>	Yes
<p>1.4 Түхайн төслийн үйл ажиллагаа нь устах аюултай төрөл зүйлд эрсдэл учруулж байна уу?</p>	No
<p>1.5 Төсөл нь түрэмгийлэх шинж чанартай гадны төрөл зүйлийг нэвтрүүлэх эрсдэл учруулах үү?</p>	No
<p>1.6 Төсөл нь байгалийн ойг тайрч, тариалж үржүүлэх ажил эрхэлж, эсвэл дахин ойжуулах ажлыг хамруулж байгаа юу?</p>	No
<p>1.7 Төсөл нь загасны популяци эсвэл усан орчны бусад төрөл зүйлийг үржүүлэх мөн/эсвэл ургац, гарцыгм хурааж авах үйл ажиллагаа агуулсан үү?</p>	No
<p>1.8 Төсөл нь гадаргын эсвэл гүний усны нөөцийг олборлох, ус татамж байгуулах, эсвэл усны нөөцийг тогтоон барих байгууламж зэрэг үйл ажиллагааг багтаасан үү? <i>Жишээлбэл, боомт болон хиймэл усан сан барьж байгуулах, голын сав газрын дагуу бүтээн байгуулалт, гүний усны олборлолт хийх гэх мэт</i></p>	Yes
<p>1.9 Төсөл нь гарал зүйн ухаан буюу генетикийн нөөц эх үүсвэрүүдийг ашиглах үйл ажиллагааг багтаасан үү? (ж нь, нөөцийг цуглуулах мөн/эсвэл ургац, гарцыг хураан авах, арилжааны зорилгоор боловсруулах)</p>	No
<p>1.10 Төсөл нь хил дамнасан эсвэл дэлхийн хэмжээний байгаль орчны сөрөг нөлөөлөл бүй болгож болзошгүй байна үү?</p>	No
<p>1.11 Төсөл нь нийгэм болон байгаль орчны сөрөг нөлөөлөлд хүргэж болох хөгжлийн хоёрдогч эсвэл түүнээс болж үүдсэн логик дэс дараалал бүхий үйл ажиллагаанд хүргэж болзошгүй юу, эсвэл энэ нь түхайн бүс нутагт хэрэгжүүлж байгаа эсвэл хэрэгжүүлэхээр төлөвлөсөн бусад үйл ажиллагаануудад хуримтлагдсан хэмжээний үр нөлөөлөл үзүүлэх үү? <i>Жишээлбэл, ойтой газар нутгаар дамжин өнгөрөх шинэ зам нь хүрээлэн буй байгаль орчин ба нийгмийн хувьд шууд нөлөөллийг бий болгоно (жишээлбэл мод тайрах, газар шорооны ажил, оршин суугчдыг нүүлгэн шилжүүлэх гэх мэт). Шинэ зам нь хууль бус оршин суугчдын зүгээс хөрш залгаа газар луу зөвшөөрөлгүйгээр халдах үйл ажиллагааг дэмжиж байж болох юм эсвэл тус замын чиглэлийн дагуу, магадгүй эмзэг газар нутагт чиглэсэн арилжааны зорилготой төлөвлөгдөөгүй бүтээн байгуулалтын ажлыг бий болгож байж болзошгүй юм. Эдгээр шууд бус, хоёрдогч, эсвэл өдөөн хандуулсан нөлөөллүүдийг нь харгалзан авч үзэх хэрэгтэй байдаг. Мөн үүнтэй ижил төстэй үйл ажиллагааг нөгөө ойн бүс нутагт хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байдаг тул, хэд хэдэн үйл ажиллагааны үр дүнд хуримтлагдах үр нөлөөллийг нь харгалзан авч үзэх хэрэгтэй байдаг.</i></p>	No

Стандарт 2: Уур амьсгалын нөлөөллийг бууруулах ба дасан зохицох		
2.1	Санал болгож буй төсөл нь ихээхэн хэмжээний ² хүлэмжийн хий ялгаруулахад хүргэж эсвэл уур амьсгалын өөрчлөлтийг улам нэмэгдүүлэхэд хүргэх үү?	No
2.2	Төслийн үр дүнд гарч болох үр дүн нь уур амьсгалын өөрчлөлтийн байж болохуйц сөрөг нөлөөлөлд мэдрэг эсвэл эмзэг байх үү?	Yes
2.3	Санал болгож буй төсөл нь одоо эсвэл ирээдүйд уур амьсгалын өөрчлөлтийн нийгэм болон байгаль орчны эмзэг байдлыг шууд болон шууд бус замаар нэмэгдүүлэх магадлалтай юу ? (үүнийг бас хангалттай бөгөөд зохих түвшинд дасан зохицож чадаагүй байдал гэдэг) <i>Жишээлбэл, газар ашиглалтын төлөвлөгөөнд гарсан өөрчлөлт нь ялангуяа шар усны үерт автах нөхцлийг улам дэвэргэх зэргээр уур амьсгалын өөрчлөлтийн өмнө хүн амын эмзэг байгаа байдлыг улам нэмэгдүүлж байж болзошгүй юм.</i>	No
Стандарт 3: Нутгийн ард иргэдийн эрүүл мэнд, аюулгүй байдал болон ажиллах нөхцөл		
3.1	Төслийн төлөвлөлт, үйл ажиллагаанд оруулах, эсвэл хэрэгжүүлэхээ болих үед нь орон нутгийн ард иргэдэд аюулгүй байдлын боломжит эрсдлийг буй болгох үү?	No
3.2	Төсөл нь аюултай бодис болон аюултай материалыг (ж нь тэсэрч дэлбэрэх бодис, шатахуун болон бусад химийн бодисуудыг) тээвэрлэх, хадгалан агуулах, ашиглах мөн/эсвэл хаяж устгахтай холбоотойгоор нутгийн ард иргэдийн эрүүл мэнд болон аюулгүй байдалд боломжит эрсдлийг учруулах үү?	No
3.3	Тухайн төсөлд томоохон хэмжээний дэд бүтцийн бүтээн байгуулалтын ажил орж байгаа юу? (ж нь, боомт, зам, барилга гэх мэт)	No
3.4	Төслийн дэд бүтцийн барилгын ажлын бүрэлдэхүүн хэсэг нь нурахаас болж нутгийн ард иргэдэд эрсдэл учруулах үү? (ж нь, барилга болон дэд бүтэц нурах)	No
3.5	Санал болгож буй төсөл нь газар хөдлөлт, нам дор газар, хөрсний гүлсалт, элэгдэл, үер, эсвэл уур амьсгалын эрс тэс нөлөөнд өртөмтгий болгож эсвэл ийм нөхцөлд хүргэх үү?	No
3.6	Төсөл нь эрүүл мэндэд учирч болзошгүй эрсдэлд хүргэх магадлалтай юу? (ж нь, усаар дамждаг эсвэл бусад дамжуулагч, тараагчаас үүдэлтэй үүсдэг өвчин эсвэл HIV/AIDS зэрэг халдварт өвчнөөс үүдэх)	No
3.7	Төслийг төлөвлөх, үйл ажиллагааг явуулах, үйл ажиллагааг нь эцэслэн зогсоох үед биет, химийн, биологийн, радиологийн аюулаас болж ажил мэргэжлийн эрүүл ахуй, аюулгүй байдалтай холбоотой байж болох эрсдэл болон эмзэг байдлыг учруулдаг үү?	Yes
3.8	Уг төсөл нь үндэсний болон олон улсын хөдөлмөрийн стандартыг (жишээлбэл, ОУХБ-ын үндсэн конвенцуудын зарчим, стандартуудыг) дагаж мөрдөх боломжгүй ажил эрхлэлт эсвэл амьжиргааг дэмжих байдлаар хэрэгжиж байгаа юу?	No
3.9	Төсөл нь орон нутгийн ард иргэд мөн/эсвэл хувь хүмүүсийн эрүүл мэнд болон аюулгүй байдалд болзошгүй эрсдэлийг үүсгэх магадлалтай аюулгүй байдлын бие бүрэлдэхүүнийг татан оролцуулж байна үү? (ж нь хангалттай хэмжээний зохих сургалт эсвэл хариуцлагагүйгээс болоод)	No
Стандарт 4: Соёлын өв уламжлал		
4.1	Санал болгож буй төсөл нь түүхэн, соёлын, урлагийн, үндэсний эсвэл шашны үнэ цэнэ бүхий эсвэл соёлын биет бус хэлбэр бүхий (ж нь, мэдлэг, инноваци, практик арга туршлага гэх мэт) тухайн газар, бүтэц байгууламж, эсвэл объектод сөрөг нөлөөлөл үзүүлэх магадлалтай төслийн хөндлөнгийн оролцоонд хүргэх үү? (Соёлын өв уламжлалыг хадгалан, хамгаалах зорилготой төслүүд заримдаа санамсаргүйгээр сөрөг нөлөөлөл үзүүлж болдог байна.)	No

² CO₂ буюу хүлэмжийн хийн ялгарлын хувьд, 'ихээхэн хэмжээний ялгарал' гэдэг нь ерөнхийдөө нэг жил тутам 25,000 тон-оос илүү хэмжээний ялгарлыг зааж байдаг (шууд болон шууд бус эх үүсвэрийн аль алианаас нь). [Хүлэмжийн хийн ялгарлын талаарх нэмэлт мэдээллийг Уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөллийг бууруулах болон дасан зохицох Удирдамж тэмдэглэгээнд тусгасан байдаг.]

4.2	Төсөл нь биет болон биет бус хэлбэрийн соёлын өвийг арилжааны болон бусад зорилгоор ашиглахыг санал болгож байна уу?	No
Стандарт 5: Нүүлгэн шилжүүлэх болон Дахин нутагшуулах арга хэмжээ		
5.1	Уг төслийн хүрээнд түр зуурын эсвэл байнгын мөн бүрэн эсвэл хэсэгчилэн биет нүүлгэн шилжүүлэх ажлыг хамарсан байх боломжтой юу?	No
5.2	Төсөл нь эдийн засгийн шинжтэй нүүлгэн шилжүүлэх үйл ажиллагаанд хүргэж болзошгүй юу? (ж нь, биет шилжүүлэн суурьшуулалт хийгээгүй боловч – газар олж авах эсвэл газрын хүртээмжийг хязгаарласан үйл ажиллагаанаас болоод эд хөрөнгөө эсвэл нөөц баялгаа алдах)	No
5.3	Төсөл нь шүүхээр өмчлөх эрхийг нь хасах үйл ажиллагаанд хүргэх эрсдэл бий юу? ³	No
5.4	Санал болгож буй төсөл нь газрын эдэлбэрийн хэлбэрийн зохицуулалт мөн/эсвэл нутгийн ард иргэдэд түшиглэсэн өмчийн эрх/нутгийн заншилд үндэслэгдсэн газар, нутаг дэвсгэр ба/эсвэл байгалийн нөөцийн эрхэд нөлөөлж магадгүй байна уу?	Yes
Стандарт 6: Нутгийн уугуул ард иргэд		
6.1	Төслийн хүрээнд хамарч буй газар нутагт (төслийн нөлөөллийн бүсийг хамруулаад) нутгийн уугуул ард иргэд байдаг уу?	Yes
6.2	Төсөл эсвэл төслийн зарим нэг хэсэг нь нутгийн уугуул ард иргэдийн эзэмшиж буй газар болон нутаг дэвсгэрт байрших магадлалтай байна уу?	Yes
6.3	Санал болгож буй төсөл нь нутгийн уугуул ард иргэдийн хүний эрх, газар нутаг, байгалийн нөөц, нутаг дэвсгэр, уламжлалт амьжиргаанд нь нөлөөлөх магадлалтай байна уу? (нутгийн уугуул ард иргэд тийм газар нутагт хууль ёсны эрхийг эзэмшиж байгаа эсэхээс үл хамааран, төслийн нөлөөлөлд өртөж байгаа ард иргэдийн оршин сууж буй газар болон нутаг дэвсгэрийн дотор эсвэл гадна нь төсөл байрлаж байгаа эсэхээс үл хамааран, эсвэл нутгийн уугуул ард түмэн тухайн улс орны уугуул ард түмэн гэж хүлээн зөвшөөрөгдсөн эсэхээс үл хамааран) <i>Хэрэв хурдавчилсан дүн шинжилгээний 6.3-р асуултанд “тийм” гэж хариулсан бол байж болох эрсдлийн нөлөөллийг байж болохуйц хүнд мөн/эсвэл ноцтой гэж авч үзэх бөгөөд уг Төслийг дунд зэргийн эсвэл өндөр эрсдэлтэй хэмээн ангилах болно.</i>	No
6.4	Авч үзэж буй нутгийн уугуул ард иргэдийн эрх, ашиг сонирхол, газар, байгалийн нөөц, нутаг дэвсгэр, уламжлалт мэдлэгт нөлөөлж болохуйц асуудлаар чөлөөтэйгөөр, урьдчилан, мэдээллийн хүртээмж дээр тулгуурлан санал нэгдсэн зөвшилцөлд (FPIC) хүрэх зорилгоор, соёлын хувьд зүй зохистой хэлэлцүүлэг, зөвлөгөөнүүдийг зохион байгуулаагүй байсан уу?	No
6.5	Санал болгож буй төсөлд, нутгийн ард иргэдийн эзэмшиж буй газар болон нутаг дэвсгэрт байгалийн нөөцийн ашиглалт ба/эсвэл арилжааны зорилготой боловсруулалтын ажлыг агуулсан байгаа юу?	Yes
6.6	Газар, нутаг дэвсгэр, байгалийн нөөцийн хүртээмжийг хязгаарлах замаар, нутгийн ард иргэдийн өмчлөх эрхийг нь хүчээр шүүхээр хасах үйл ажиллагаа эсвэл бүхэлд нь эсвэл хэсэгчилсэн байдлаар эдийн засгийн зорилгоор нүүлгэн шилжүүлэх магадлал бий юу?	No
6.7	Нутгийн ард иргэдийн хувьд өөрсдийнх нь тодорхойлсон хөгжлийн тэргүүлэх асуудалд төслийн зүгээс сөргөөр нөлөөлөх үү?	No
6.8	Төсөл нь нутгийн ард иргэдийн биет болон соёлын хувьд оршин тогтноход нь нөлөөлөх боломжтой юу?	No

³ Хүчээр шүүхээр өмчлөх эрхийг нь хасах үйл ажиллагаа гэдэгт хувь хүмүүс, бүлэг, нутгийн ард иргэдийг тэдний эзлэн оршиж байсан эсвэл хамаарч амьдарч байсан гэр орноос нь ба/эсвэл газар болон нийтийн өмчийн эх үүсвэрээс нь албадан эсвэл сайн дураар нь нүүлгэн шилжүүлсэн үйлдлийг хамруулсан үйлдэхүй ба/эсвэл эс үйлдэхүйг хамруулж үздэг байна. Ингэснээрээ тухайн хувь хүмүүс, бүлэг, нутгийн ард иргэдийг зохих хууль эрх зүйн болон бусад хамгааллын хэлбэрийг ашиглах, түүнийг хүртэх эрх байхгүй л бол, тодорхой орон сууц, оршин суугаа газар эсвэл байршилд оршин сууж эсвэл ажиллах боломжийг нь үгүй хийдэг байна.

6.9	Төсөл нь нутгийн уугуул ард иргэдийн уламжлалт мэдлэг эсвэл арга туршлагыг арилжааны хэлбэрт оруулж эсвэл ашиглах замаар тэдний Соёлын өв уламжлалд нөлөөлж болзошгүй байна уу?	No
Стандарт 7: Бохирдлоос урьдчилан сэргийлэх болон Байгалийн нөөцийн үр ашигтай ашиглалт		
7.1	Төсөл нь орон нутгийн, бүс нутгийн ба/эсвэл хил дамнасан болзошгүй сөрөг нөлөөлөл бүхий тогтсон болон тогтсон бүс дэг журмын үлмаас хүрээлэн буй байгаль орчинд бохирдуулагч бодис алдах эрсдэл байж болох уу?	No
7.2	Санал болгож буй төсөл нь хог хаягдлыг үүсгэн бий болгоход нөлөөлж болзошгүй байна уу? (аюултай болон аюултай бус хог хаягдлын аль аль нь)	Yes
7.3	Санал болгож буй төсөл нь юултай химийн бодис мөн/эсвэл материалыг үйлдвэрлэх, худалдаалах, ялгаруулах, мөн/эсвэл ашиглах үйл ажиллагаа явуулах магадлалтай юу? Төсөл нь олон улсын хэмжээнд хориглосон эсвэл хэрэглээг нь аажмаар халах нөхцөлтэй химийн бодис эсвэл материалыг ашиглахыг санал болгож байгаа юу? <i>Ж нь, Удаан задардаг органик бохирдуулагчийн тухай Стокольмын конвенц эсвэл Монреалийн Протокол зэрэг олон улсын конвенцэд жагсаасан байдаг DDT, PCBs болон бусад химийн бодисууд.</i>	No
7.3	Санал болгож буй төсөл нь байгаль орчин, хүний эрүүл мэндэд сөрөг нөлөө үзүүлж болзошгүй хортон шавьжийг устгах химийн пестицидийн хэрэглээг хамруулах уу?	No
7.5	Төсөлд түүхий эд, эрчим хүч, мөн/эсвэл ус ихээхэн хэмжээгээр шаардагдах үйл ажиллагааг багтсан байгаа юу?	No